



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/280

Улаанбаатар хот

Чингэлтэй дүүргийн 39 дүгээр
цэцэрлэгийн данснаас барилга
байгууламж, нийтийн эзэмшлийн
эд хөрөнгө хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 96 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/708 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн 2019 оны 02-07-136/283 дугаар дүгнэлтийн дагуу Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах, энэ тушаалын хавсралтад заасан 427,915,843 /дөрвөн зуун хорин долоон сая есөн зуун арван таван мянга найман зуун дөчин гурван/ төгрөгийн үнэ бүхий барилгыг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Чингэлтэй дүүргийн 39 дүгээр цэцэрлэг /Ц.Батцэцэг/-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Чингэлтэй дүүргийн 39 дүгээр цэцэрлэг /Ц.Батцэцэг/-т даалгасугай.

3. Хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдах боломжтой материалыг хөндлөнгийн үнэлгээний байгууллагын үнэлсэн 5,148,700.0 /таван сая нэг зуун дөчин найман мянга долоон зуун/ төгрөгөөр худалдан борлуулж, орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэхийг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /Н.Раднаасэд/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 07. дугаар сарын 31... өдрийн 1/280 дугаар тушаалын хавсралт

АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ,
НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

/төгсгөөр/

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ /2019.03.31/
1	Барилга байгууламж	1960	м.кв	802	375,326,000	364,378,991.59	10,947,008,41
2	Цэвэр усны шугам	1960	м	50	2,040,000	2,040,000	-
3	Цэвэр усны шугам	2009	м	50	9,970,000	9,970,000	-
4	Дулааны шугам	2000	м	50	6,152,951	6,152,951	-
5	Дулааны шугам	1960	м	50	25,921,000	25,921,000	-
6	Бохирын шугам	1960	м.куб	40	1,860,000	1,860,000	-
7	Цахилгааны шугам	1960	м	112	302,400	302,400	-
8	Зүлэгжүүлсэн талбай	1963	м.кв	772	3,551,200	-	3,551,200
9	Бетон зам	1630	м.кв	485	1,164,000	1,164,000	-
10	Бут сөөг	1972	ш	3	288	-	288
11	Төмөр хашлага	2015	м	144	1,296,000	442,800	853,200
12	Элсний хашлага	2011	м	13	212,004	192,129.06	19,874.94
13	Навчит мод	1965	ш	50	120,000	-	120,000
НИИТ ДҮН					427,915,843	412,424,271.7	15,491,571.4